



**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

20~~20~~ оны ~~08~~ сарын ~~00~~ едэр

Дугаар 8/174

Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 32 дугаар 32.7 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Үнэлгээний хорооны 2020 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 121 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх БСШУСЯ/202001272 дугаартай Есөнбулаг сумын 2 дугаар сургуулийн спорт заалны барилга угсралтын ажлыг "Жигүүр-Эрдэнэ" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ч.Бат-Эрдэнэ)-т олгосугай.

2. Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ч.Бат-Эрдэнэ)-т, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (М.Ууган-Эрдэнэ)-т наарт үүрэг болгосугай.

3. Санхүүжилтийн гүйцэтгэл, ажлын чанарт хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Т.Энхцэцэг), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (П.Баасан), Мэргэжлийн хяналтын газар (Г.Гантулга)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ГАНБАТ